



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 841

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 509,456,170.00 (таван зуун есөн сая дөрвөн зуун тавин зургаан мянга нэг зуун дал) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсүгэй.

2.1. Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн, тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

2.2. “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах;

2.3. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд орсон нэмэлт өөрчлөлтийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр компанийн дүрэмд оруулах;

3. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (Л.Эрхбаатар)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай;

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

3.2. Төрийн эзэмшлийн газар дээр байрлах зөвшөөрөлгүй хоёр ширхэг түргэн үйлчилгээний цэгийн барилгыг нүүлгэн шилжүүлэх, төрийн эзэмшил газрыг чөлөөлүүлэх арга хэмжээ авч ажиллах;

3.3. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хийгдсэн их засварын ажлаас буусан хөрөнгийн хэмжээгээр үндсэн хөрөнгийн дүнг бууруулж бүртгэх, өргөтгөн шинэчлэх ажлын дүнд үүссэн компанийн хашаанд хураалттай байгаа шугам хоолой, бетонон тулгууруудыг байгууллагын Өмч хамгаалах Байнгын

зөвлөлөөр хэлэлцүүлэн, хоёрдогч түүхий эдээр үнэ тогтоон худалдан борлуулах арга хэмжээ авах;

3.4.Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтгүй байгаа хүлэмжийн барилгыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.5-д “Ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй боломжгүй болсон нь мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон” үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасах гэж заасны дагуу холбогдох арга хэмжээг авах;

3.5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах;

3.6.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх;

3.7.Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

4.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
2023 дугаар тогтоолын хавсралт



ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ, ТҮҮНИЙГ АРИЛГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд дутуу төвлөрүүлсэн хөрөнгө	Захирал Л.Эрхбаатар Ерөнхий ня-бо П.Пүрэвсүрэн	184,769,740.0	Монгол улсын хөдөлмөрийн хууль, Засгийн газрын 2022 оны "Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам батлах тухай" 253 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах
2	Батлагдсан журамгүйгээр компанийн ТУЗ- ийн хараат бус гишүүдэд олгосон үр дүнгийн урамшуулал	Захирал Л.Эрхбаатар Ерөнхий ня-бо П.Пүрэвсүрэн	11,475,000.0	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах,
3	Хууль тогтоомж зөрчин үргүй зардал гаргасан	Захирал Л.Эрхбаатар Ерөнхий ня-бо П.Пүрэвсүрэн	85,796,100.0	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г мөрдөж ажиллах
4	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил, үйлчилгээг санхүүжүүлсэн	Захирал Л.Эрхбаатар Ерөнхий ня-бо П.Пүрэвсүрэн	197,038,100.0	Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам"- ыг мөрдөж ажиллах,
5	Цар тахлын нөхцөлд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллах тухай Эрчим хүчний сайдаас өгсөн удирдамж, чиглэлийг зөрчсөн	Захирал Л.Эрхбаатар Ерөнхий ня-бо П.Пүрэвсүрэн	30,377,200.0	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г мөрдөж ажиллах
	Дүн		509,456,170.0	(таван зуун есөн сая дөрвөн зуун тавин зургаан мянга нэг зуун далан) төгрөг